

2025 оны 4 сарын 17-ны өдөр

№ 2025/22

Улаанбаатар хот

Сонирхолын зөрчилтэй
хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1, 92.4 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн Б.Солонгод 190,000,000 (нэг зуун ерэн сая) төгрөгийн зээлийг дараах нөхцөлөөр олгохыг зөвшөөрсүгэй.

Зээлийн хүү	22.8% /жилийн /
Зээлийн хугацаа	6 сар
Зээл олголт шимтгэл	1%

2. Зээлийн барьцаанд Улсын бүртгэлийн Y-2203025144 тоот дугаартай, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 6 хороо, Бага тойруу, 48 байрны 49 тоот хаягт байршилтай, 61.32 м.кв талбайтай, 2 өрөө, Орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийг барьцаалж, барьцааны гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулан зээлийн гэрээ болон барьцааны гэрээ байгуулах, компанийг төлөөлж холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т, зээл олголтыг хийхийг эрхийг Санхүү эрхэлсэн захирал (Ч.Гэндэнпил) нарт тус тус олгосугай.

4. Энэхүү санал хураалтад сонирхлын зөрчилгүй этгээдүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурдсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ